



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.12.25 № 03/10663
танай _____ -ны № _____ -т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан БШУЯ/20240101099 дугаартай “Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 7 дугаар хороо/” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Бапкер” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Бапкер” ХХК-ийн ирүүлсэн гомдолд захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Таван од констракшн” ХХК ажил гүйцэтгэх хугацааны графикт хүн/цагийг тусган тооцоолж гаргаагүй, ажлын талбайтай танилцсан тэмдэглэлийг фото зургийн хамт ирүүлээгүй, барилгын инженер Н.Мөнхдоржийн мэргэжлийн диплом нь цахим системд байршаагүй, гадаад улсад төгссөн боловч дипломын баталгаат орчуулга ирүүлээгүй, халаалт, агаар сэлгэлтийн инженер Б.Батсайханы диплом мөн адил цахим системд бүртгэгдээгүй, Н.Мөнхдорж, С.Мөнхжаргал ямар албан тушаалтайгаар төсөлд оролцох нь тодорхойгүй мөн маягт 6, маягт 7-г ирүүлээгүй байх тул хянан үзэхийг хүссэн байна.

Гомдолд дурдсан үндэслэлээр захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Таван од констракшн” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2-т “Ажил гүйцэтгэх үе шатны ажлын хуваарийг баталгаажуулан ирүүлэх ба ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь 2026 оны 12 дугаар сарын 25-ны өдөр байна.” гэж заасны дагуу “Таван од констракшн” ХХК тендерт дээрх ажлыг гүйцэтгэх хуваарийг ирүүлсэн байна.

Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт ажил гүйцэтгэх хүн/цагийг тооцоолж ирүүлэх талаар заагаагүй тул “Таван од констракшн” ХХК ажил гүйцэтгэх хуваарьт дээрх тооцооллыг гаргаж ирүүлээгүй гэх гомдол үндэслэлгүй байна.

2. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2-т “Ажлын талбайтай танилцсан тэмдэглэлийг фото зургийн хамт ирүүлнэ.” гэж заасны дагуу талбайтай танилцсан байдлыг зураг, тэмдэглэлийн хамт ирүүлсэн байх тул дээрх мэдээллийг ирүүлээгүй гэх гомдол үндэслэлгүй байна

3. “Таван од констракшн” ХХК тендерт материал нууцалж ирүүлээгүй байх тул “Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт” маягт 7-г ирүүлээгүй гэх гомдол үндэслэлгүй байна.

4. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Ерөнхий инженер. Мэргэжил: Барилгын инженер (мэргэшсэн болон түүнээс дээш зэрэгтэй байх). Барилгын инженер. Мэргэжил: Иргэний ба үйлдвэрлэлийн барилгын инженер” гэж, мөн ТШЗ 19.2-т “Тендерт оролцогчийн үндсэн ажилтан, хөлсөөр ажиллах гэрээний дагуу ажиллах ажилтны мэдээллийг цахим систем дэх V бүлэгт заасан маягт 2-ааор зааварчилгааны дагуу санал болгоно. Цахим системээр санал болгоогүй тохиолдолд хянан үзэхгүй.” гэж заасан байна.

“Таван од констракшн” ХХК худалдан авах ажиллагааны цахим системээр Н.Мөнхдоржийг барилгын ерөнхий инженерээр, С.Мөнхжаргалыг барилгын инженерээр тус тус санал болгосон байх тул дээрх ажилчид ямар албан тушаалтайгаар төсөлд оролцох нь тодорхойгүй гэх гомдол үндэслэлгүй байна.

Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт ажилчдыг гүйцэтгэх үүргийн хувьд захирлын тушаалаар томилсон байх шаардлага заагаагүй байх бөгөөд Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 2.13-т “Оролцогчоос ирүүлсэн тендер энэ журмын 2.3.6-д заасны дагуу цахим системийн холбогдох талбарт оруулсан мэдээлэлтэй зөрвөл цахим системийн мэдээллийг баримтална.” гэж заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим системээр санал болгосон хүний нөөцийн мэдээллийг үнэлгээнд харгалзан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

5. Тендер шалгаруулалтын баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2-т “3.Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох дараах баримт бичиг ирүүлнэ. Үүнд: Оролцогчийн туршлагыг харуулах заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн маягт 4, 6-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл ирүүлнэ. Мэдээллийг нотлох баримт бичиг ирүүлнэ. Үүнд: - Ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, -Улсын комисс хүлээж авсан актын хуулбар, - Захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ. Ижил төстэй ажилд Барилга угсралтын ажил хийж гүйцэтгэсэн туршлагыг тооцно.” гэж заасан байна.

“Таван од констракшн” ХХК ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээллийг тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэгт заасан маягт 6-ын дагуу ирүүлээгүй байх боловч 2020, 2021, 2022, 2023, 2024 онд гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт, захиалагчийн тодорхойлолт зэрэг маягт 6-д заасан мэдээллийг нууцлалгүйгээр ирүүлснийг тендер шалгаруулалтын баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2-т заасан дээрх шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

6. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Ерөнхий инженер. Мэргэжил: Барилгын инженер (мэргэшсэн болон түүнээс дээш зэрэгтэй байх)” гэж, мөн ТШЗ 19.2-т “а)Тендерт оролцогчийн үндсэн ажилтан, хөлсөөр ажиллах гэрээний дагуу ажиллах ажилтны мэдээллийг цахим систем дэх V бүлэгт заасан маягт 2-аар зааварчилгааны дагуу санал болгоно. Цахим системээр санал болгоогүй тохиолдолд хянан үзэхгүй. б) Ажилтны сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй, төрийн мэдээлэл, солилцооны ХУР системээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана.

(Тендерт оролцогч нь Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia)-д ажилтны дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг урьдчилан шалгах шаардлагатайг анхаарна уу.) Хэрэв санал болгож буй ажилтан нь гадаад улсад сургууль төгссөн бол дипломын хуулбарыг орчуулгын хамт ирүүлнэ.” гэж заасан байна.

Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт дипломын баталгаат орчуулга ирүүлэх талаар заагаагүй байх тул “Таван од констракшн” ХХК тендерт санал болгосон Н.Мөнхдоржийн дипломын баталгаат орчуулга хавсарган ирүүлээгүй гэх гомдол үндэслэлгүй байна.

Түүнчлэн “Таван од констракшн” ХХК тендерт Н.Мөнхдоржийг барилгын ерөнхий инженерээр санал болгосон байх бөгөөд “Н.Мөнхдорж нь 2002 онд Энэтхэг Уулсын Бунделхандийн их сургуульд иргэний ба үйлдвэрийн барилгын инженер мэргэжлээр 0009347 дугаартай бакалаврын дипломтой төгссөн нь дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгэлтэй байна” гэх Боловсролын ерөнхий газрын 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 1/1068 тоот тодорхойлолтод үндэслэн тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1, ТШЗ 19.2-т заасан дээрх шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

7. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Халаалт, агаар сэлгэлтийн инженер” гэж, мөн ТШЗ 19.2-т “а)Тендерт оролцогчийн үндсэн ажилтан, хөлсөөр ажиллах гэрээний дагуу ажиллах ажилтны мэдээллийг цахим систем дэх V бүлэгт заасан маягт 2-оор зааварчилгааны дагуу санал болгоно. Цахим системээр санал болгоогүй тохиолдолд хянан үзэхгүй. б) Ажилтны сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй, төрийн мэдээлэл, солилцооны ХУР системээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. (Тендерт оролцогч нь Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia)-д ажилтны дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг урьдчилан шалгах шаардлагатайг анхаарна уу.) Хэрэв санал болгож буй ажилтан нь гадаад улсад сургууль төгссөн бол дипломын хуулбарыг орчуулгын хамт ирүүлнэ.” гэж заасан байна.

Түүнчлэн Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 2.5-д “Захиалагч цахим системтэй холбогдсон мэдээллийн сангаас дараах журмаар ирүүлсэн тендер шалгаруулалт зарласнаас хойших мэдээллийг тендер хянан үзэхэд үндэслэл болгоно. Үүнд: 2.5.3.хуульд заасан эрх бүхий этгээдээс олгосон зөвшөөрөл (энгийн болон тусгай)-ийн мэдээлэл, авто тээврийн хэрэгслийн эзэмшигчийн лавлагаа, дээд боловсролын дипломын мэдээлэл, санхүүгийн тайлан зэрэг бодит цагийн горимоор дамжуулдаг, өдөр тутам өөрчлөгддөггүй мэдээлэл.” гэж заасан.

“Таван од констракшн” ХХК худалдан авах ажиллагааны цахим системээр Б.Батсайханыг халаалт, агаар сэлгэлтийн инженерээр санал болгосон байх бөгөөд тендерт 1998 оны С9807479 дугаартай барилгын коллежийн дипломыг хавсарган ирүүлсэн байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/286 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Боловсролын баримт бичгийн тодорхойлолтыг төрийн үйлчилгээний цахим машинаас олгох журам”-ын 2.5-д “2018 оноос өмнө

олгогдсон боловсролын баримт бичгийг архивын ерөнхий газар болон сургалтын байгууллагын архивын мэдээлэл, статистикийн мэдээлэлд тус тус үндэслэн мэдээллийн системд Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистик, мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж хянасны үндсэн дээр оруулна...” гэж заасан байх тул “Таван од констракшн” ХХК-ийн тендерт санал болгосон Б.Батсайханы диплом тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2-т заасан шаардлагад нийцэх эсэхийг нягтлан үзэж Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын 5.9-д заасныг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллана уу.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: “Бапкер” ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ